



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 01

Бүрхээр

“Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатарын хотын Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Бага тойруу, Могоул тауэр, 508 тоот хурлын танхимд 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14 цаг 00 минутад эхэллээ.

Хуралд нийт 829622 /Найман зуун хорин есөн мянга зургаан зуун хорин хоёр ширхэг хувьцааг төлөөлж хувьцаа эзэмшигч оролцохоос саналын эрх бүхий энгийн хувьцааны 738084 ширхэг хувьцаа эзэмшигчид хуралд оролцож, ирц 89%-тай байгаа нь Компанийн тухай хуулийн 69 дугаар зүйлийн 69.4 дэх заалтыг хангасан учир Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай танилцуулав. /Тооллогын комиссын тогтоолыг хавсаргав/

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд: Хувьцаа эзэмшигч

№	Овог нэр	Регистрийн дугаар	Хувьцааны тоо
1	Орон нутгийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц. Бэхбаяр	РУ77111018	423107
2	“Транс нефт” ХХК-ийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н. Батдорж	204660399777	124444
3	Ж. Батболд	ТЕ64010314	135451
4	Л. Батдэлгэр	ЙТ54081510	23067
5	Ч. Гүнсэнноров	ЙТ60021503	15098
6	Н. Батдорж	МЭ64102919	178
7	Т. Бат-Очир	РС62112614	1311
8	Д. Янжмаа	РЭ54032485	13
9	Ц. Сүхбаатар	ЙЮ73020271	37
10	Ч. Төрмандах	ЧА85033175	5
11	Х. Эрдэнэсанаа	ХА74020504	1

12	Ж. Баатар	ЧТ50102571	1
13	Н. Учрал	ЦТ84082404	3
14	Б. Батсайхан	ОЮ70091091	508
15	Б. Буянтогтох	657577399072	1419
16	Г. Ганзориг	РЮ81042318	25
17	С. Пүрэвжав	ЛЮ84121391	212
18	Г. Алтансүх	ПЭ81031711	7
19	П. Нямдорж	ШД80120714	6
20	С. Мягмарсүрэн	ХТ84091817	392
21	П. Хүдэртулга	ЧЖ78021915	8359
22	Д. Алтансүх	ЧР70102875	137
23	Булган брокер ҮЦХ ХХК	2008157	4180
24	Д. Эрдэнэчимэг	ЧФ50112565	113
Хуралд оролцсон нийт дүн			738084

Хурлын дарга: Н. Батдорж

Тооллогын комиссын дарга: Л. Шинэцэцэг

Тооллогын комиссын гишүүн: С. Даш

Тооллогын комиссын гишүүн: Т. Бат-Очир

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга: С. Мөнх-Эрдэнэ

Компанийн гүйцэтгэх захирал Л. Батхүү нар оролцов.

Хурлын дарга хурлыг нээж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө болон хурлын дэг, хуралд хүрэлцэн ирсэн орон нутгийн өмчийн төлөөлөл, хувьцаа эзэмшигчдийг танилцуулж, хурлыг нээв.

Сонссон нь:

Н. Батдорж (хурлын дарга):

Тооллоын комиссын дарга Л. Шинэцэцэг та ирцийн мэдээллийг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Л. Шинэцэцэг:

Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрх бүхий энгийн хувьцааны 738084 ширхэг буюу нийт хувьцааны 89 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид

оролцож байна. Энэ нь "Компанийн тухай хууль"-ийн 69 дүгээр зүйлийн 69.4 дүгээр хэсэгт заасан шаардлагыг хангаж байна.

Н. Батдорж (хурлын дарга):

-Өнөөдрийн хурлаар

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны тайланг дүгнэж, 2025 оны ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоож, зардлын төсвийг батлах;
3. Компанийн ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг мэдээлэх
4. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудлыг тус тус хэлэлцэнэ.

Хурлын дэгийг танилцуулъя.

№	Хурлын дэг	Хариуцах эзэн	Хугацаа
1	Хурын ирц бүртгэх	Ажлын хэсэг	14:00-14:10
2	Хурлын ирц мэдээлэх	Ажлын хэсэг	14:10-14:15
3	Хурал нээж хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	Хурлын дарга	14:15-14:25
4	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт танилцуулах	ТУЗ-ийн дарга	14:25-14:40
5	Асуулт, хариулт, санал дүгнэлт	Хурлын дарга	14:40-14:50
6	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны тайлан танилцуулах	ТУЗ-ийн дарга	15:10-15:30
7	Асуулт, хариулт, санал дүгнэлт	Хурлын дарга	15:30-15:40
8	Санал хураалт (Тогтоолын төсөл -1)	Ажлын хэсэг	15:40-15:50
9	ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээ, 2025 оны зардлын төсөв батлах тухай тогтоолын төсөл танилцуулах	Хурлын дарга	15:50-16:00
10	Асуулт, хариулт, санал дүгнэлт	Хурлын дарга	16:00-16:10
11	Санал хураалт (Тогтоолын төсөл-2)	Хурлын дарга	16:10-16:20
12	Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг мэдээлэх, тогтоолын төсөл танилцуулах	Хурлын дарга	16:20-16:30
13	Асуулт, хариулт, санал дүгнэлт	Хурлын дарга	16:30-16:40
14	Санал хураалт (Тогтоолын төсөл-3)	Ажлын хэсэг	16:40-16:50
15	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай, тогтоолын төсөл танилцуулах	Нэр дэвшүүлэх хороо	16:50-17:10
16	Асуулт, хариулт, санал дүгнэлт	Хурлын дарга	17:10-17:20

17	Санал хураалт (Тогтоолын төсөл-4)	Ажлын хэсэг	17:20-17:30
18	Санал хураалтын дүнг танилцуулах	Тооллогын комисс	17:30-17:40
19	Хурлаас гарсан шийдвэр, тогтоолыг танилцуулах	Хурлын дарга	17:40-17:50
20	Хурлыг хаах	Хурлын дарга	17:50-18:00

Хурлыг хаах гэсэн хуралдааны дэг байна. Дэгээ батлах уу?

Хуралд оролцогчдын 100%-ийн саналаар дэг батлагдав.

Н. Батдорж (хурлын дарга):

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчидээ!

Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн оролцоотой “Могойн гол” хувьцаат компани нь байгуулагдан, нүүрс олборлох үйл ажиллагаа эрхлээд 55 дахь жилтэйгээ золгож байна.

Манай компанийн үе үеийн уурхайчид, бүтээлч хамт олон өнгөрсөн 54 жилийн хугацаанд нийт 2,8 сая тонн нүүрс олборлон Хөвсгөл, Завхан аймгийн эрчим хүчний байгууллагууд болон бусад хэрэглэгчидэд өндөр чанарын коксжих нүүрс нийлүүлсэн байна.

Манай компани нь Монгол улсын “Компанийн тухай хууль” болон олон улсын хэмжээнд мөрдөж буй “Компанийн засаглалын кодекс”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, нийт хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар манай компанийн хувьцааг нийт 1000 орчим хувьцаа эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж 53 брокер, диллерийн компаниудаар дамжуулан эзэмшиж байна. Үүнээс манай компанийн хувьцаа эзэмшигч дэлхийн 13 орны гадаадын иргэн байгаа нь тус компанийн үйл ажиллагаа цаашид өргөжин тэлж, үр өгөөж нь өсөн нэмэгдэх тодорхой итгэл найдварыг та бидэнд хүлээлгэсэн хүндтний үүрэг юм.

Сүүлийн жилүүдэд буюу 2021-2023 онд “Могойн гол” ХК-ийн үйл ажиллагаа нь бүх талуудын санаачлага, дэмжлэгээр тодорхой хэмжээгээр өсөн дээшилж, эдийн засгийн үр ашиг өсөн нэмэгдсэн юм.

Гэвч нээлттэй хувьцаат компанийн хувьд компанийн нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт бүрэн нийцсэн, орон нутгийн хөгжилд үр өгөөж өгөхүйц бизнесийг хурдацтай, даацтай хөгжүүлж хараахан чадаагүй байна.

Ялангуяа сүүлийн 1-2 жилийн хугацаанд компанийн борлуулалтын орлого болон цэвэр ашиг эрс буурч хувьцаа эзэмшигчдэд, ногдол ашиг хувиарлах боломжгүй болсонд та бүхнээсээ уучлал хүсэж байна.

2023 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн “Уул уурхайн бүтээгдхүүний биржийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан манай компани нь коксжих нүүрсээ уг хуулийн дагуу DAP-Эрээн нөхцлөөр биржийн дуудлага худалдаагаар худалдан борлуулах болсон.

“Уул уурхайн бүтээгдхүүний биржийн тухай” хуулийн дагуу компанийн ТУЗ-с холбогдох шийдвэрүүдийг гаргаж, улмаар компанийн гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлэх талаар

тодорхой ажлуудыг зохион байгуулсан боловч гадаад зах зээлд коксжих нүүрсээ борлуулж чадагүй л байна..

Цаашид компанийн өмнө тулмагдсан олон асуудлыг оновчтой шийдвэрлэж, Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засагт болон нийт хувьцаа эзэмшигчдэд хүртээх үр өгөөжийг улам нэмэгдүүлэх томоохон зорилтыг дэвшүүлэн ажиллах болно.

Хувьцаа эзэмшигчид Та бүхэн компанийхаа өнөөгийн байдалд бодитой дүгнэлт хийж,хэлэлцэж буй асуудлуудад анхаарлаа хандуулан,дэвшүүлсэн зорилт санал,санаачлагыг дэмжин,"Компанийн тухай "хуулийн хүрээнд оновчтой шийдвэрийг гарган,хөгжил дэвшилд хамтадаа хүрэхийг уриалж байна.

Одоо та бүхэнд "Орон нутгийн өмчийн төлөөлөгч томилох тухай" Хөвсгөл аймгийн Засаг даргын захирамж, мөн Транснефт компанийн төлөөлөгчийн итгэмжлийг уншиж танилцуулъя. Хэмээн уншиж танилцуулав.

За дарааллын дагуу эхний асуудлаа хэлэлцье.

Хэлэлцсэн нь:

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Сонссон нь:

Компанийн гүйцэтгэх захирлын албан үүргийн түр орлон гүцэтгэгч Б. Батхүү компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн талаар мэдээлэл өгөв.

Н. Батдорж (хурлын дарга):

- За компанийн мэдээлэлтэй танилцлаа. Асуулттай хувьцаа эзэмшигч байна уу?

Хувьцаа эзэмшигч Мягсарсүрэн:

- Компанийн өр төлбөр яагаад ийм өндөр байна вэ ?

Н. Батдорж (хурлын дарга):

- Уул уурхайн биржийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр манай компани экспортын нүүрсээ зарж чадахгүй байдалд хүрсэн.

-Эрчим хүчний нүрсээ Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан үнийн дагуу бодит өртөгөөс нь доогуур үнээр худалдаалдаг.

Хувьцаа эзэмшигч Сүхбаатар:

- Өр төлбөрийн ихэнх нь ямар зардалтай холбоотой байна вэ? Өр төлбөрийг бууруулах тал дээр хэрхэн ажиллах вэ?

Ж. Батболд (хувьцаа эзэмшигч):

- Компанийн ТУЗ-д ажилласан хувьцаа эзэмшигчийн хувьд хариулахад өр төлбөрийн ихэнх нь гэрээгээр хөрс хуулаж ажил гүйцэтгэсэн оператор компаниудад өгөх төлбөр, тэсэлгээний бодисын төлбөр, шатахууны төлбөр зэрэг байгаа. Түрүүн хэлсэнчлэн экспортын нүүрсээ борлуулж чадахгүй нөхцөл үүссэн учраас эдгээр төлбөрийг барагдуулж чадалгүй өр үүссэн.

- Биржийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, экспортын нүүрсээ худалдаалахаар 3 том тендэр зарлаад оролцогч шалгараагүй. Өөрөөр хэлбэл Уурхайгаасаа гааль хүртэл тээвэрлэхийн тулд эхлээд Мөрөнгөөс Эрдэнэт хүртэл авто машинаар тээвэрлэх тендэр, Эрдэнэтэд нүүрсээ буулгах гаалийн баталгаат талбайн тендэр, Эрдэнэтээс Замын-Үүд хүртэл төмөр замаар тээвэрлэх тендэрүүдэд оролцогч шалгарч байж биржээр дуудах боломжтой болох байсан. Гэвч хэд хэдэн удаа зарлаад одоо болтол оролцогч шалгараагүй байна.

- Компанийн гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн дарга болон миний бие экспортын нүүрсээ боруулах тал дээр Уул уурхай эрдэс баялагийн яам, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар гээд хөөцөлдөөгүй газар байхгүй. Биржийн хуулиар манайх шиг жижиг уурхайнууд хүнд байдалд орж байгаа талаар ярьж, ойлгуулж хөөцөлдсөн.

- Ашгүй одоо Биржийн тухай хуулиа эргэн харах, уурхайн амнаас зарж болох талаар хуулийн төсөл боловсруулаад эхэлсэн байна.

- Цаашид экспортын нүүрсээ борлуулаад эхэлчихвэл өр, төлбөрөө бүрэн барагдуулчих боломж бий.

Хувьцаа эзэмшигч Алтансүх:

- Аудитын тайлан дээр компанийн өр төлбөр нь эздийн өмчөөс даваад явчихсан байна. Компанийн тухай хуулиар 10 хоногийн дотор дахин хөрөнгөжүүлэх энтэр гэсэн асуудал байдаг.

- Түүнтэй холбоотойгоор 2016 онд Сангийн сайдын баталсан Уул уухайн компаниудад нягтлан бодох, үнэлгээ хийх аргачлал гэж бий. Тиймээс компанийн үнэлгээгээ хийлгээд явсан нь дээр байх. Цаашид энэ зөрчил Аудит дээр байнга гараад явна.

Н. Батдорж (хурлын дарга):

- Алтансүх хувьцаа эзэмшигч үнэтэй санал хэллээ. Цаашид анхааръя.

Ц. Бэхбаяр (Орон нутгийн өмчийг төлөөлж хуралд оролцогч):

- Хөвсгөл аймгийн 51%-ийн өмчийг төлөөлж Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож буй аймгийн ОНӨГ-ын дарга Бэхбаяр гэж хүн байна.

- Энэ компанитай тодорхой хэмжээнд хувьд заяагаа холбоод, ТУЗ-д нь 5 удаа сонгогдоод ажиллаж байна. Сүүлийн 4 жил завсарлаад буцаад орж ирж байна.

- Өр төлбөрийн хувьд нилээн өндөр болжээ. Гэхдээ энэ нь үйлдвэрлийг урагш явуулахын тулд гэрээ, хэлцлүүд хийгдсэн юм байна.

- Үүнийг хийхэд Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-аас компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасан их хэмжээний хэлцлийн зөвшөөрлүүд өгөгдсөн юмуу?

- Хоёрдугаарт өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө юм байна уу ?

- Бид бүхэн дотооддоо ямар төлөвлөгөө боловсруулж ажиллаж байгаа вэ ?

- Одоо энэ компанийг хүлээгээд авахад жаахан айдастай байх тоонууд харагдаж байна шүү ?

Н. Батдорж (хурлын дарга):

- Асуултад хариулъя. Их хэмжээний хэлцэл гэж компанийн тухай хуулиар компанийн хөрөнгийн 1/3-ээс дээш хэмжээтэй хэлцлийг ойлгож байгаа.

Гэрээ хэлцүүд явахын өмнө гүйцэтгэх захирал ТУЗ-д танилцуулаад шийдвэр гаргуулж явч байгаа.

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б. Батхүү:

- Та бүхэн компанийн үйл ажиллагааны танилцуулга дээрээс нөхцөл байдал ямар байгаа вэ гэдэг талаар мэдээлэл авсан байх аа.

- Их хэмжээний хэлцлийн хувьд өнгөрсөн онд бид ХААН банкны лизингээр тэсэлгээний өрөм худалдан авсан,

- Энэ өрөм энэ жилийн хөрс хуулалтад маш их үүрэг гүйцэтгэж байгаа.

- 2023 онд өрөмгүй байснаас хөрс хуулалтад маш их бэрхшээл үүссэн.

- Мөн Завхан аймгийн Тосонцэнгэл суманд байгуулагдсан "Тосон Энержи" компанитай нүүрс борлуулах гэрээ байгуулсан. Энэ бүхэнд ТУЗ-өөс шийдвэр гаргуулж байсан.

- Энэ компанийн зүгээс жилийн 130 мянган тонн нүүрс авах саналаа ирүүлсэн.

- Бид энэхүү компаниас 2 тэрбум төгрөгийн урьдчилгаа авсан, одоо энэ компаниас 4 тэрбум төгрөгийн авлагатай байгаа. Энэ компаниас авлагаа аваад, коксжих нүүрсээ зараад эхэлчихвэл одоо энд үүссэн байгаа хүндрэлээсээ гарчих боломж бий.

Гэвч эрчим хүчний нүүрсийг Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон үнэ 42500 төгрөг дээр НӨАТ нэмэгдээд 46750 төгрөгөөр зарч байгаа нь нүүрсээ олборлож буй бодит өртөгөөс даруй 30000 төгрөгөөр бага байгаа.

Өнгөрсөн жилийн 10 дугаар сард ТУЗ-ийн шийдвэрээ гаргуулж 1 тонн нүүрсийг 75000 төгрөг байх саналаа Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлсэн боловч Хороо хуралдаагүй, харин энэ 4 дэх өдөр хуралдах гэж байна.

Энэ батлагдчихвал Эрчим хүчний нүүрсээ алдагдалгүй борлуулах боломжтой болно.

Хувьцаа эзэмшигч Нямдорж:

- Асуулт гэхээсээ илүү санал хүсэлт байна. Могойн гол компанийн хувьд хөрөнгө оруулагчийн хувьд үнэ цэнтэй компани байна гэж үзээд хөрөнгө оруулсан. Өнгөрсөн жилүүдэд засаглалын тодорхойгүй байдлаас хамаарч үйл ажиллагаа нь доголдож байсан. Зарим тохиолдолд хурлаа ч хийж чадахгүй нөхцөл байдал үүсч байсан. Үүн дээрээ анхаараарай.

- Нүүрсний хувьд өнгөрсөн хоёр жилд өндөр үнэтэй байсан. Энэ үед учраа олцгоохгүй яваад байсан. Цаашдаа анхаараарай.

- Одоо энэ хурлаар шинэ ТУЗ байгуулагдана. Энэ бол зөвхөн Орон нутгийн эсвэл томоохон хувьцаа эзэмшигчийн ч юмуу эсвэл жижиг хувьцаа эзэмшигчдийн асуудал биш бүгдэнгийнх нь асуудал учраас цаашид зөв ойлголцоод нэг чиглэлээ хараад компаниа үр ашигтай ажиллуулахын тулд хамтраад ажиллах нь зөв байх.

- Миний бие Хөрөнгийн Биржэд ажилладагийн хувьд хэлэхэд Сангийн сайдын мэдээлж буйгаар нүүрсийг цаашид Биржээр худалдаална. Гэхдээ хууль шинэчлэгдэнэ. Гэхдээ биржээр худалдаалах байр суурь өөрчлөгдөхгүй.

- Цаашдаа биржээр худалдаалах арга хэмжээгээ яаралтай аваад явах тал дээр энэ ТУЗ анхаараарай.

- Саяны үйлдвэрлийн асуудлаар хувьцаа эзэмшигчид нилээн ойлголт авлаа.

- Түрүүчийн ТУЗ-ийн Батболд гишүүний танилцуулсан тэр Тосонгийн цахилгаан станцад нүүрсээ худалдаалдаг болсон нь маш сайн ажил болжээ. Энэ дээр та бүхэнд баяр хүргэе ээ.

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б. Батхүү:

- Биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг бид нар тууштай хийж байгаа. Үүн дээр 2024 оны 9 дүгээр сараас 3 төрлийн тендэрийг аймгийнхаа Худалдан авах ажиллагааны газарт захиалга өгч зарлуулсан.

Энэ нь Уурхайгаас Эрдэнэт рүү нүүрсээ автомашинаар тээвэрлэх тендэр, Эрэнэтэд буулгах талбайн тендэр, Эрдэнэтээс Замын-Үүд хүртэл төмөр замын тендэр гээд. Энэ тендэрүүд дээр оролцогч орж байж биржээр худалдаалах боломж бүрдэнэ. Нийт 4 удаа тендэр зарлаад саяхан автомашинаар тээвэрлэх тендэр болон Эрдэнэтээс төмөр замаар Замын-Үүд хүртэл тээвэрлэх тендэрүүд шалгарч байна.

Хөрөнгийн биржээс нүүрсний чанарын шинжилгээ хийлгэх зөвлөгөө өгсний дагуу шинжилгээгээ хийлгэсэн.

Хөрөнгийн биржээс худалдан борлуулагчийн батламжаа авчихсан байгаа.

Нэг хүндрэлтэй нөхцөл үүссэн нь биржийн тухай хууль гарахаас өмнө нь урьдчилгаа аваад хэд хэдэн компаниудтай гэрээ байгуулчихсан байсан. Хууль гарснаас хойш энэ компаниудад гарал үүсэл нь олдохгүй байдалд хүрсэн. Бид эдгээр компаниудын гарал үүслийг хөөцөлдөж байгаа. Хэрэв гарал үүсэл нь гарчихвал энэ гэрээ хийсэн компаниудаас 20 тэрбум төгрөг орж ирэх боломж бүрдэнэ.

Н. Батдорж (хурлын дарга):

-За үнэтэй санал хэлж, асуулт асуусан хувьцаа эзэмшигч Нямдорж танд талархлаа.

- Өөр асуулттай хувьцаа эзэмшигч байна уу?

Хувьцаа эзэмшигч Баатар:

- Би Могойн голын нүүрсний уурхайг их ашигтай уурхай болно гэж боддог юм.

- Коксжих нүүрс 30-70%-ийг эзэлдэг гэж дурдаж байна. Төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн асуудлууд байна.

- Цаашид дотоодын нүүрсээ худалдан авагчаа нэмэгдүүлэхэд анхаараарай.

-Могойн голынхон асар холоос нүүрсээ тээвэрлэж гаргана. Хил дээр байгаа уурхайнууд өөр. Ийм ялгаатай нөхцлийг тооцож энэ уурхайг дэмжих хэрэгтэй.

- Биржийн арилжааг харж байхад Эрдэнэс таван толгойн нүүрс л зарагдаад байдаг бусад нь зарагдахгүй байгааг холбогдох төрийн байгууллагууд анхаармаар байна.

- Шинэ ТУЗ-д 50% нь өөрчлөгдөж байгаа юм байна. Цаашид сайн ажиллаарай.

- Хувьцаа эзэмшигчдийн хурлаа энд хийж байгаад баяртай байна. Өөр зүйлгүй ээ.

Н. Батдорж (хурлын дарга):

- За баярлалаа.

- Би нэг мэдээллийн чанартай юм хэлчихье.

- Бид нар хувьцаа эзэмшигчдийн хурлаа Улаанбаатарт 2 дахь удаагаа хийж байгаа. Оролцогчид ч нэмэгдэж байна.

- Биржийн тухай хууль манай уурхайд маш хүндээр тусч байгаа. Өнгөрсөн 12 дугаар сард Уул уурхайн яам дээр Биржийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд энэ ажлын хэсэгт манай гүйцэтгэх захирал орсон. Бид хүндрэл, бэрхшээлүүдийнхээ талаар ярьж, бичгээр саналаа өгсөн байгаа.

Хувьцаа эзэмшигч Ж. Батболд: Монголд нүүс олборлож буй компаниудын нүүрсний зах зээлийн үнэ, нүүрс боловсруулах талаар хийсэн судалгаа, цаашид хүндрэлээс гарах арга замын талаар мэдээлэл өгөв.

Хувьцаа эзэмшигч Төрмандах:

- Компанийн санхүүгийн нөхцөл байдал биржийн тухай хууль болон бусад асуудлуудаас болоод алдагдалтай гарчээ. Технологийн хувьд хөрс хуулалт болон нүүрс олборлолтын харьцааны коэффициент нь 10 гараад явчихжээ. Овоолгын зай болон бусад нөхцлүүд нь ямархуу байгаа бол? Олборлолтын өртгийг бууруулах тал дээр ямар шийдэв вэ? Түрүүн цахилгаан экскеватор, канверын системийн талаар ярьж байна. Энэ маань хөрөнгө оруулалтын өртөг нь маш өндөр.

- Түрүүн Батхүү захирлын ярианаас 2023 оны 6 дугаар сараас хэрэгжсэн биржийн тухай хуулин хэрэгжилтийг хангаж ажил 2024 онд эхэлсэн байна. Биржийн тухай хууль гарах нь, мөрдөх нь тодорхой байсан. Хөвсгөл аймгийн хувьцаа эзэмшигчдийн эрхийн үүднээс орон нутгийн удирдлагууд ямар дэмжлэг үзүүлж байгаа юм?

- Биржийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд Орон нутаг ямар дэмжлэг, оролцоотой байгаа вэ?

Ж. Батболд:

- Хувьцаа эзэмшигч маш чухал асуудлыг хөндөж буйд баяртай байна.

Манай хувьд хөрс хуулалтын коэффициент 10%-д хүрсэн. Маш өндөр болсон. Бид үүнээс гарах замыг эрэлхийлж байгаа.

- Бидний нэг давуу тал овоолгын зай бага.

- Одоо байгаа жижиг тоног төхөөрөмжөө ашиглаад зардлаа бууруулах боломж бий.
- Цаашид цахилгаан тоног төхөөрөмж ажиллуулж, өртөг, зардлаа бууруулах боломж бий.
- Том зорилтод хүрэхийн тулд цаашдын үе шаттай техникийн шинэчэл хийх хэрэгтэй. Цаашдаа бид хувьцаа эзэмшигчиддээ мэдээллээд явна.

Б. Батхүү (Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч):

- Бид биржийн тухай хуулийн хэрэгжилтийг эртнээс хангасан.
- Хууль батлагдахаас өмнө санхүүгийн нөхцөл байдлаа сайжруулах үүднээс 20 компанитай гэрээ байгуулж урьдчилгаа авч байж үйл ажиллагаагаа 2023 онд зогсоолгүй явуулсан.
- Ингээд биржийн хэрэгжилтийг хангах үүднээс тасралтгүй ажилласан. Гэвч тендэр шалгаруулалтад оролцогч оролцохгүй өдий хүрсэн.

Ц. Бэхбаяр (Орон нутгийн төлөөлөгч):

- Би 4 жил тасраад орж ирлээ.
- Миний байсан 4 жилд Могойн гол хамгийн өндөр ашигтай байсан.
- Өнгөрсөн 4 жилийг муулах нь хаашаа юм.
- Өнгөрсөн 4 жилд нүүрсний үнэ сайн байсан. Харамсалтай нь орон нутагтайгаа ойлголцоогүй, улс төрийн бойкотод орсон. Боломжоо алдсан.
- Тийм учраас орон нутагтайгаа ойлголцох, Хөвсгөл аймгийн иргэд, жижиг хувьцаа эзэмшигчдийн сэтгэл ханамжийг өндөр байлгах үүднээс бид хамтран ажиллах ёстой.
- Хувьцааг эргэлтэд оруулахын тулд бид ярилцах ёстой.
- Цаашдаа орон нутаг яаж дэмжих юм бэ гэж. Өнгөрсөн хугацаанд зах зээлийн хүнд үед 2 аймгийн хөлдөөлгүй авч байсан. Тэр үед арай хийж амиа тээсэн.
- Хөвсгөл аймаг маань Уул уурхайгүй Хөвсгөл гээд иргэний хөдөлгөөний хөөсрөл ихтэй аймаг.
- Тийм учраас Өмнөговийн нутгийн хишиг гэдэг шиг иргэдэдээ тодорхой хувь хүртээх тал дээр бид нар бодож ажиллаж байгаа.
- Жижиг хувьцаа эзэмшигчдийн зүгээс мэдээллээ ил тод болгох үүднээс бид бүхэнтэй хамтарч ажиллаарай.

Хувьцаа эзэмшигч Мягмарсүрэн:

- Тээвэрлэлтийн асуудал дээр орон нутгийн иргэд эсэргүйцээд байдаг гэсэн ойлголцож чадсан уу?
- Хоёрдугаарт ногдол ашгаа авмаар байна. 2024 онд 600 төгрөг гээд зарласан байсан. Санхүүгийн тайлан дээр бүртгэгдсэн байна. Яг хэзээ тараах вэ?

Б. Батхүү (Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч)

- Тээвэрлэлтийн хувьд стандартын хязгаарлалт байдаг. Энэ нь манай борлуулалтад асар их дарамж учруулж байгаа. Энэ нь тээврийн хөлсийг асар өндөр болгодог.
- Үүнийг орон нутаг шийдэхэд бас хүндрэлтэй юм билээ. Яагаад гэвэл дээрээс гарсан стандартыг хэрэгжүүлэхээс аргагүй болдог.
- Өвлийн хүндрэлтэй үед нэг тэнхлэг дээр 10 тонн гэж зааж Засаг даргын захирамж гарсан байгаа.
- Ногдол ашгийн хувьд "Тосон Энержи" компаниас авлагаа авчихвал 4,5 сардаа багтаад өгчих боломжтой гэж үзэж байгаа.
- Одоогоор аль ч хувьцаа эзэмшигчиддээ тараагаагүй байгаа.

Н. Батдорж (хурлын дарга):

- За та бүхэнд баярлалаа.
- Дэлгэрэнгүй асуулт, хариулт явчихлаа.
- Одоо цаг хэмэх үүднээс 2, 3 дугаар асуудлыг аль алиныг нь танилцуулъя.

Хэлэлцсэн нь:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны тайланг дүгнэж, 2025 оны ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоож, зардлын төсвийг батлах;

Н. Батдорж (хурлын дарга):

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны тайланг танилцуулж, 2025 оны ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээ, зардлын тооцоог танилцуулав.

Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, саналтай гишүүд байна уу?

Хувьцаа эзэмшигч Төрмандах:

- Компани алдагдалтай ажиллаж байхад ТУЗ-ийн зардлыг яагаад нэмээд байна вэ ?
- Хоёрдугаарт Төрийн төлөөллийг хэрэгжүүлэх тухай ЗГ-ын тогтоол гарсан.
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байхаар заасан.

Н. Батдорж (хурлын дарга):

- Бид 2025 онд үйлдвэрлэлээ нэмэгдүүлэхээр зорьж байгаа. Тиймээс зардлаа бага зэрэг нэмэгдүүлж ирсэн.
- Манай компани нээлттэй хувьцаат компани учраас Хувьцаа эзэмшигчдийн хурлаасаа шийдээд явах боломжтой.

Ж. Батболд (Хувьцаа эзэмшигч):

- Манай ТУЗ-ийн гишүүдийн үүрэг, хариуцлага нэмэгдэж байгаа.
- Тиймээс бид жишигийг судалж үзээд ТУЗ-ийн гишүүдийн урамшууллыг нэмэгдүүлсэн.

Хувьцаа эзэмшигч Эрдэнэчимэг:

- Танайх хэдэн байгууллагад борлуулалт хийж байгаа вэ? Борлуулалтаа нэмэгдүүлмээр байна.
- Хөвсгөл аймгийн 50 гаруй аж ахуйн нэгж, Завхан аймгийн Бүх сум, аймгийн төвийн дулааны станц, Тосонцэнгэл сумын цахилгаан станцад борлуулалт хийж байгаа. Цаашид нэмэгдүүлнэ.
- Аймгуудад өгч буй эрчим хүчний нүүрснээс ашиг байхгүй, алдагдалай ажиллаж байгаа.
- Цаашдаа нүүрсээ шууд зарах бос баяжуулалт хийж гадагшаа үнэ хүргэж зарж байж л ашигтай ажиллана.

Н. Батдорж (хурлын дарга):

Өөр асуулт, санал байхгүй бол дараагийн асуудал руугаа оръё.

Хэлэлцсэн нь:

Компанийн ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг мэдээлэх

Н. Батдорж (хурлын дарга):

Компанийн ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулав.

Сонссон нь:

Н. Батдорж (хурлын дарга):

- Асуух асуулт, саналтай хувьцаа эзэмшигчид байна уу?

Хувьцаа эзэмшигчид:

- Байхгүй.

Хэлэлцсэн нь:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай;

Сонссон нь:

Нэр дэвшүүлэх хорооны дарга Ж. Батболд:

- "Могойн гол" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн сонгон шалгаруулах тухай чиглэлийг ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороонд чиглэл болгосны дагуу нээлттэй зарыг өдөр тутмын хэвлэл, "Өдрийн сонины" 2025 оны 03-р сарын 25-ны өдрийн №052 дугаарт нийтлүүлсэн.

Энэхүү зарын дагуу 2025 оны 03-р сарын 31-ний өдрийн 17 цаг хүртэлх хугацаанд нэр дэвшигчдийн хүсэлт, холбогдох материалыг олон нийтээс нээлттэйгээр, зөвхөн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга С. Мөнх-Эрдэнийн Munkherdene.sainbayar@gmail.com хаягаар цахимаар хүлээн авсан.

Дээрх хугацаанд нийт 5 нэр дэвшигчийн материал ирснийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга С. Мөнх-Эрдэнэ нээж, цаг хугацааны дарааллаар эрэмблэн, хэвлэж Нэр дэвшүүлэх хорооны даргад 2025 оны 04-р сарын 01-ний өдөр хүлээлгэн өгсөн.

Нэр дэвшүүлэх хороо 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр хуралдаж, иргэн Цогтоо нь манай компанитай бизнесийн холбоотой "Хөвсгөл дулааны станц" ТӨК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан тул үнэлэхээс татгалзах хассан. Бусад 4 нэр дэвшигчийн материалыг шалгуурын дагуу үнэлэж хамгийн өндөр оноо авсан Н. Нэргүй, Б. Түмэндэлгэр, Д. Мөнхбат нарыг дэвшүүлэхээр тогтоолоо гарган хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсанд бичиж хүргүүлсэн.

- Мөн өнөөдөр аймгийн ИТХ-аас хараат бус гишүүнд Ч. Оюунчимэг, Н. Очирбат гэж хүмүүсийн материалыг цаасаар ирүүлсэн.

- Орон нутгийн өмчийн төлөөлөгч Бэхбаяр хэлэхдээ цахимаар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 17 цаг 26 минутад хүргүүлсэн гэж байгаа.

- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга энэ хүмүүсийн материал цахимаар ирсэн эсэх талаар мэдээлэл өгнө үү.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С. Мөнх-Эрдэнэ:

- ТУЗ-ийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтын зарыг өдрийн сонинд тавьсан бөгөөд зарын дагуу нэр дэвшигчид цахимаар материалаа ирүүлсэн.

- 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр материал хүлээн авах хугацаа дуусахаас хэдхэн хормын өмнө ИТХ-ын ажилтан хараат бус гишүүнд нэр дэвшүүлэхээр 2 хүний материалыг цаасаар барьж орж ирсэн.

- Миний бие зарын дагуу цахимаар авна, цаасаар авах боломжгүй талаар хэлээд гаргасан.

- Энэ хүний материалиуд миний мэйлээр ирээгүй, мэйл илгээсэн зургийг харахад и-мэйл хаягийг андуурч илгээсэн байна.

Н. Батдорж (хурлын дарга):

Нэр дэвшүүлэхтэй холбоотой асуулт, саналтай хувьцаа эзэмшигч байна уу?

Ц. Бэхбаяр (Орон нутгийн өмчийн төлөөлөгч)

- За энэ 2 хүний хувьд хэдийгээр хараат бус ч гэсэн орон нутаг, ИТХ-тай хамтран ажиллах саналаа тавиад материалаа 31-ний өдөр өгсөн.

- Материалаа өгөхөд нь цахимаар авна гээд буцаасан буцаагаад явуулахад нь цаг дууссан юмуу хаашаа юм ийм асуудал үүссэн.

- Энэ асуудал бол миний мэдэхийн 2, 3 жил үүсч байгаа.

- Нэр дэвшүүлэх хороонд 3 хараат бус гишүүн өөрсдөө орчихдог.

- Нөгөө 3 чинь өөрсдөө олонх болчихдог. Санал дүгнэлтээ хувьцаа эзэмшигчдийн хурал руу оруулаад ирдэг.

- Энэ нөхдүүд байна л даа тэр Нэргүй, Түмэндэлгэр гээд энэ нөхдүүд 3 жил явчихлаа. Тэр Мөнхбатыг нь хуучин байсан, үгүйг нь мэдэхгүй юм байна.

- Энэ 3 нөхөр цаашдаа орон нутгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлээд явах уу? , үгүй юу? гэдэг бүрхэг. Тэгэхээр өнөөдөр би ямар санал хэлэх гээд байна вэ гэхээр, өнөөдөр би хувьцаа эзэмшигчийн хувьд, та нар бас хувьцаа эзэмшигчийн хувьд энэ 4 орж ирсэн, 2 хоцорч ирсэн энэ 6 нөхрийнхөө нэрийг зоогоод саналыг нь өгөөд явъя аа гэдэг горимын санал гаргаж байгаа юм.
 - Үгүй бол хувьцаа эзэмшигчийн кумулятив аргаар сонгох болохоор үгүй бол бүгдээрээ хүчингүй болно, бас хувьцаа эзэмшигчдийн хурал дахин зарлагдана, нэр дэвшүүлэх хороо дахин хуралдана.
 - Тэгэхээр энэ хурал дээрээ бүгдээрээ энэ асуудлаа цэгцлээд явъя аа.
 - Шахаж байгаад энэ Нэргүй, Түмэндэлгэр гэдэг 2 хүн ороод ирлээ. Хараат бус гишүүн бол хараат бус гишүүн.
 - Эд нар дээр гэдэг юмуу хувьцаа эзэмшигчдийн зүгээс нөлөөөх боломж байдаггүй.
 - Энэ хүн өөрийнхөө эрх ашгийн төлөө ажилласан ч болно.
 - Тийм учраас өнгөрсөн 2 жил бидний ашигтай байх боломжийг алдагдуулсан хүмүүс энэ 2 байх ч боломжтой.
 - Тийм учраас аймгийн ИТХ-ын захирамжаар би удирдамж аваад хүрээд ирсэн, энэ 2 хүнийг дэмжихгүй ээ, Оюунчимэг, Очирбат гэж хоёр хүнийг дэмжинэ гээд.
 - Гэтэл нөгөө 2 хүн нь энд байдаггүй.
 - Одоо ахиад гацаа чинь эндээс эхлэх гээд байна шүү нөхөд өө.
 - Тэгэхээр ямар санал явуулах гээд байна вэ гэхээр саналын хуудас дээр нэр дэвшсэн 6 хүнээ нэмж оруулаад хувь хувийнхаа саналыг өгчихье.
- Хувьцаа эзэмшигч Нямдорж:
- За би үүн дээр саналаа хэвье.
 - Энэ компанид төрийн төлөөлөл, хувийн төлөөлөл, төрийн эрх ашиг гэсэн юм байхгүй ээ. Энэ бол бүх хувьцаа эзэмшигчдийн асуудал л яригдана.
 - Хоёрдугаарт энэ асуудал хуулийн дагуу явах ёстой.
 - Хуулиар Нэр дэвшүүлэх хороо тавигдсан шалгуур, шаардлагын дагуу хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулна. Нэр дэвшүүлэх хорооны шалгаруулалтын үйл явцад хэн ч хөндлөнгөөс хэнч халдах эрх байхгүй. Ялангуяа төр байна уу? Аймгийн Засаг дарга байна уу? Ерөнхий сайд байна уу ? хөндлөнгөөс нөлөөлөхгүй.

- Тиймээс хуулиа барьж ажиллах ёстой.
- Үнэхээр шалгуур, шаардлага хангаагүй, материалаа зарын дагуу өгөөгүй бол хууль, дүрэм, журмынхаа дагуу л явах ёстой.
- Санал өгөх, өгөхгүй байх нь хувьцаа эзэмшигчийн эрх, Орон нутгийн төлөөллийн хараат бус гишүүн гэж хэзээ ч байхгүй, том хувьцаа эзэмшигчийн төлөөллийн хараат бус гишүүн гэж байхгүй.
- Хараат бус гишүүн хуулиараа асар их хариуцлага хүлээдэг, хараат бусаар үйл ажиллах ёстой. Магадгүй эрүүгийн хариуцлага ч хүлээн эрсдэлтэй алба.
- Энэ дээр битгий өмчирхөөрэй.
- Шалгуур, шаардлагаа хангасан хүн дээрээ санал хураалтаа явуулаад өгөх нь зүйтэй.

Н. Батдорж (хурлын дарга):

Өөр асуулт, санал байна уу?

Хувьцаа эзэмшигч Алтансүх:

- Саяын саналыг нэмэлтээр оруулах гэдэг дээр тийм зүйл байж болохгүй байх.
- Хууль журмынхаа дагуу явах хэрэгтэй. Орон нутгийн төлөөлөл саналаа өгөх, өгөхгүй нь түүний асуудал.
- 2, 3 жилийн өмнө бас ийм юм яриад гонгиноод явж л байсан.
- Өөрсдөө үлгэрлээд явах хүмүүс энд ирчихээд ийм юм яриад байж болохгүй, бусад хувьцаа эзэмшигчдээ хүндлэх хэрэгтэй.
- За хэлэлцэх асуудлаа хаагаад санал хураалтын ажил руугаа оръё.

Тооллогын комисс ажилдаа ороорой.

Тооллогын комиссын дарга Л. Шинэцэцэг:

- Та бүхэнд санал хураалтын дүнг танилцуулъя:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг 82.6%-ийн саналаар,
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг хэлэлцэж "Хангалттай" гэж дүгнэн, 2025 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг 82.6%-ийн саналаар баталж,
3. Компанийн 2024 оны ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг 91%-ийн саналаар зөвшөөрсөн байна.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоход нийт 738037 ширхэг хувьцааны саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид оролцсон бөгөөд кумулятив аргыг ашиглаж доорх саналыг өгсөн байна. Үүнд:

№	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн овог нэр	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
Ердийн гишүүд		
1	Л. Батдэлгэр	327445
2	Ж. Батболд	311488
3	Н. Батдорж	311083
4	Г. Гандэлгэр	1580420
5	Ц. Бэхбаяр	1580420
6	Б. Нямдаваа	1580420
Хараат бус гишүүд		
7	Н. Нэргүй	311058
8	Б. Түмэндэлгэр	311049
9	Д. Мөнхбат	329310

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрөв.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 онд хийсэн ажлыг "Хангалттай" гэж дүгнэж, 2025 оны зардлын төсвийг батлав.
- Компанийн 2024 оны ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг зөвшөөрөв.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй сонгов. Үүнд:
Ж. Батболд (311488 ширхэг санал)
Н. Батдорж (311083 ширхэг санал)
Л. Батдэлгэр (327445 ширхэг санал)
Г. Гандэлгэр (1580420 ширхэг санал)
Ц. Бэхбаяр (1580420 ширхэг санал)
Б. Нямдаваа (1580420 ширхэг санал)
Хараат бус гишүүнд:
Д. Мөнхбат (329310 ширхэг санал)
Н. Нэргүй (311058 ширхэг санал)
Б. Түмэндэлгэр (311049 ширхэг) нарыг дэмжиж батлав.

ТАНИЛЦСАН

ДАРГА

Н. БАТДОРЖ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

АЖЛЫН ХЭСГИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С. МӨНХ-ЭРДЭНЭ

